Хураамж/Fee amount:	Журнал №/Journal No:	Гарын үсэг/Signature:	Банкны ажилтан №/Bank staff No:	Огноо / Date:
500	14642739		21525	2022/06/29
			Шилжүүлэгчийн регистрийн дугаар / Customer ID:	
			558707120/	

Зураг 28. Нөхөн сэргээлтийн барьцаа байршуулсан баримт





Зураг 29. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж буй байдал

ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЗЛЭГИЙН КАРТ

Овог: Ботсүх..... Нэр: Орвогтүвшин
Нас: 36..... Хүйс: эр/эм (зур)
Р.д: 13 960115 К.....
Утас: 89916410.....

ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЗЛЭГИЙН КАРТ

Овог: Баттөр..... Нэр: Дорнод
Нас: 20..... Хүйс: эр/эм (зур)
Р.д:
Утас: 92289991.....

Зураг 30. Ажилчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн карт нээсэн байдал

Сангийн сайдын 2017 оны 12
дугаар сарын 5-ны өдрийн
347 тоот тушаалын хэвсрэлт

Сүмбэр Хунтан ХХК

/Базууллагын нэр/

КАССЫН ЗАРЛАГЫН ОРДЕР №

2022 он 06 сар 21 өдөр

Харилцах данс	Дэлгэрэнгүй бүртгэлийн код	Дүн	Гүйлгээний утгын код

Хэнд “Тотон мандал” ХХК-д
/Мөнгө хүлээн авсан/

Гүйлгээний утга Ашиггүй урьдчилсан
сэргийлэх үзлэгт
2400000 төгрөг 00 мөнгө
таар сая дөрвөн зуун
мянган Төгрөг
/Үсгээр/

Ерөнхий (ахлах) нягтлан бодогч: _____

Кассын нэр: САНАА ҮҮ

Промиск №: 7730 6 2528477

Хүлээн авсан: ААТАР ХОТ

Зураг 31. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан төлбөрийн баримт

“НУУР” НЭРТЭЙ ТООСГОНЫ ШАВРЫН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ, ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

III ДААТГАЛ

ГЭРЭЭ 148.22.104.1023320002

ГЭНЭТИЙН ОСОЛ, ЭМЧИЛГЭЭНИЙ ДААТГАЛЫН ГЭ

Энэхүү “Даатгалын гэрээ” цаашид “Гэрээ” гэх/г Монгол Улсын “Иргэний хууль”-ийн 431-444 дүгээр зүйлүүд, “Даатгалын тухай хууль”-ийг тус тус үндэслэн, Нэг талаас даатгалын баталгаанд нэр заагдсан Даатгуулагч, Нөгөө талаас “Миг даатгал” ХХК/цаашид “Даатгагч”, хамтад нь “Талууд” гэх/ харилцан тохиролцсоны үндсэн дээр дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулаа.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээ нь Даатгуулагч даатгалын зүйлээ Даатгагчид даатгуулах, Даатгагч нь гэрээнд заасан эрсдэл үүссэн тохиолдолд нөхөн төлбөр олгохтой холбогдсон Талуудын хооронд үйлчилж ажиллахад оршино.
- 1.2 Даатгалын мэдүүлэг, даатгалын баталгаа нь гэрээний салшгүй нэг хэсэг болно.
- 1.3 Талууд гэрээг харилцан зөвшөөрч, гарын үсэг зурж, гэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр болж, даатгалын хураамж төлөгдөнөөр даатгалын хамгаалалт үйлчлэхэд хэлнэ.
- 1.4 Гэрээний хугацаанд даатгалын зүйл тус бүр дээр олгох нөхөн төлбөрийн дэд хэмжээ нь тухайн зүйл тус бүрийн даатгалын үнэлгээгээс хэтрэхгүй байна.
- 1.5 Энэхүү гэрээ нь “Төрийн банк” ХХК болон “Миг даатгал” ХХК-ийн хооронд 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр байгуулсан 07/654 тоот “Хамтран ажиллах гэрээ”-ний салшгүй хэсэг болно.
- 1.6 Талууд энэхүү гэрээ болон даатгалын баталгаанд заагдсан нэр томъёог “Даатгалын тухай хууль” болон бусад хууль тогтоомжид тодорхойлсон утгаар ойлгоно.
- 1.7 Даатгалын гэрээний хугацаа нь даатгалын гэрээ байгуулсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд үйлчилнэ.

Хоёр. Даатгалын зүйл, үнэлгээ, хураамж, хугацаа

- 2.1 Даатгалын зүйл нь 18 хүртэлх насны хүүхдийн болон насанд хүрсэн иргэдийн амь нас, эрүүл мэнд байна.
- 2.2 Даатгалын үнэлгээг энэхүү гэрээний 2.3-т зааснаар тогтооно.
- 2.3 Даатгалын хураамж дараах хэмжээтэй байна. Үүнд:

№	Даатгалын зүйл	Даатгалын үнэлгээ	Даатгалын хураамж
2.3.1	18 хүртэлх насны хүүхэд	1,0 сая төгрөгөөс дээш	0.38%
2.3.2	Насанд хүрсэн иргэд	2,0 сая төгрөгөөс дээш	0.70%
2.3.3	Хурдан моринь унаач хүүхэд	20,000,000	0.50%

Гурав. Даатгалын эрсдэл

- 3.1 Дараах төрлийн эрсдэлийн улмаас даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдах, аль насаа алдах, тахир дутуугийн зэрэглэл тогтоолгоход нөхөн төлбөр олгоно.
 - 3.1.1 Байгалийн эрсдэл;
 - 3.1.2 Зам тээврийн осол;
 - 3.1.3 Мал амьтдын нөлөөний эрсдэл;
 - 3.1.4 Гадны халдлагад өртөх эрсдэл;
 - 3.1.5 Ахуйн болон бусад эрсдэл /түгээдэх, хайрагдах, тосгон цохилох, усартгах, зүсэгдэх, хавчуулагдах, холдох, хальтрах, цохилох, хорт хийнд хордох, хорстий нураалт, на цохилох, паранд хардох/;
 - 3.1.6 Урлаг, спорт, сургагч, үйлдвэрлэлийн холбогдолтой осол /Үүнд олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээний үеийн осол хамаарахгүй/;
- 3.2 Хурдан моринь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгалын хувьд:
 - 3.2.1 Үндэсний их баяр наадам болон бүх түвшний хурдан моринь уралаан, түүний бэлтгэл, сунгааны үед үүсч болзошгүй бүхий л гэнэтийн осол, гэмтлийн улмаас үүдэн гя аливаа хохирол;
 - 3.2.2 Хурдан морь унах эрсдэлээс үүдэн Даатгуулагчийн амь насанд аюултай нөхцөл үүссэн тохиолдолд яаралтай шилжүүлэх, тээвэрлэлтийн зардлыг 10,000,000 төгрөг /арван хүртэлх хэмжээгээр тооцож даатгалын үнэлгээнд багтаан, даатгалын гэрээний хугацаанд нэг удаа олгоно.

Дөрөв. Даатгалын нөхөн төлбөр олгох нөхцөл

- 4.1 Даатгуулагч нь даатгалын нөхөн төлбөрийг нэхэмжлэхэд дараах бичиг баримтыг бүрдүүлэн Даатгагчид өгнө. Үүнд:
 - 4.1.1 Нөхөн төлбөрийн хүсэлт;
 - 4.1.2 Даатгалын гэрээ;
 - 4.1.3 Даатгалын тохиолдлын үе болон хохирлыг нотлох фото зураг;
 - 4.1.4 Осол болон хохирлын талаар гаргасан эрх бүхий байгууллагын акт, дүгнэлт, тодорхойлолт. Үүнд:
 - 4.1.4.1 Аварг ослын улмаас гэмтсэн, хөдөлмөрийн чадвараа алдсан тухай эмнэлгийн хуудас, магадлагаа, амбулаторийн карт, эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийд
 - 4.1.4.2 Хэрвээ Даатгуулагч нас барсан эсвэл хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн алдсан бол үүнийг нотлох мэргэжлийн байгууллагын нотолгоо, түүний хууль ёсны залгамжлагчийн нотлох баримт бичиг;
 - 4.1.4.3 Үйлдвэрлэлийн ослын акт (үйлдвэрлэлийн ослын үед);
 - 4.1.4.4 Шаардлагатай бол замын цагдаа, гал түймэр, шүүх прокурор, мөрдөн байцаах болон шүүх эмнэлгийн байгууллагаас авсан баримт, нотолгоо;
 - 4.1.5 Бусад холбогдох нэмэлт материал;
- 4.2 Даатгалын эрсдэлийн улмаас учирсан хохирлыг 100%-иар тооцож, Даатгагчаас Даатгуулагчид нөхөн төлбөр олгоно.
- 4.3 Даатгагч нь энэхүү гэрээний 4.1-д заасан баримт материалуудыг Даатгуулагчаас бүрэн хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ.
- 4.4 Даатгуулагчийн нэхэмжилсэн хохирлын хэмжээг Даатгагч үндэслэлгүй гэж үзвэл эрх бүхий даатгалын хохирол үнэлгээгээр үнэлгээг дахин хийлгэнэ. Энэ тохиолдолд хохирол шийдвэр хугацааг ажлын 22 хүртэл хоногээр сунгаж болно. Үнэлгээний зардлыг Даатгагч хариуцна.
- 4.5 Аюул осол, хохирол нь хууль сахиулах болон мэргэжлийн байгууллагаар шалгагдаж буй тохиолдолд нөхөн төлбөр шийдвэрлэх хугацааг сунгаж болно.
- 4.6 Даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, заавар, даатгалын гэрээгээр Даатгч нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, нохиол, заавар болон энэхүү даатгалын гэрээгээр зохицуулагдана.
- 4.7 Даатгалын нөхөн төлбөрийг дараах байдлаар тооцож олгоно. Үүнд:
 - 4.7.1 Даатгуулагч нас барсан тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг даатгалын үнэлгээний хэмжээгээр 100 хувь олгоно.
 - 4.7.2 Даатгуулагч гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол алдсан хоног тутамд даатгалын үнэлгээний 0,35 хувиар бодож, дээд тал нь 90 хоногийн хугацаа тооцон нөхөн төлбөр олгоно.
 - 4.7.3 Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг холбогдох эрх бүхий эмнэлгийн байгууллагын тодорхойлолтыг үнд тооцож нөхөн төлбөрийг тэрхүү тогтоосон хэмжээтэй хувь гэнцүүлэн олгоно.
 - 4.7.4 Зайлшгүй шаардлагатай нөхцөлд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, эм тарианы зардалд зориулан даатгалын үнэлгээнээс 3.0-аас 5.0 хувиар бодож тохиолдол тутамд н төлбөр олгоно.
 - 4.7.5 Даатгуулагч нас барсан буюу хүндээр гэмтсэн тохиолдолд яаралтай шилжүүлэн тээвэрлэхэд олгох нөхөн төлбөрийг тээвэрлэлтийн зардлын хэмжээгээр тооцож олгоно.
- 4.8 Хурдан моринь уралаанч хүүхдийн даатгалын хувьд:
 - 4.8.1 Даатгуулагч гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол түүний эмнэлгээт хэвтсэн, амбулатори болон гэрээр эмчлүүлсэн эмнэлгийн хуудсыг үндэслэн ал хоног тутамд даатгалын үнэлгээний 0,2 хувиар бодож дараах нөхцөлөөр нөхөн төлбөр олгоно.
 - 4.8.2 Нэг удаагийн тохиолдлоор 30 хүртэлх хоногийн нөхөн төлбөр олгох ба жилдээ дээд тал нь 3 удаа олгоно.
 - 4.8.2.1 Даатгуулагч даатгалын эрсдэлээс үүдэн нас барсан тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг даатгалын үнэлгээний хэмжээгээр 100 хувь олгоно.
 - 4.8.2.2 Даатгуулагч гэнэтийн ослын улмаас тахир дутуу болсон тохиолдолд даатгалын үнэлгээнээс дараах хувь хэмжээгээр тооцож нөхөн төлбөр олгоно. Үүнд:

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь	Нөхөн төлбөрийн хэмжээ
90-100%	100%
80-89%	90%
70-79%	80%
60-69%	70%
50-59%	60%

- 4.9 Даатгагч нөхөн төлбөрийг олгосон нөхцөлд буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зарч хэмжээгээр даатгагчид шилжинэ.
 - 4.10 Даатгалын нөхөн төлбөрийг зөвхөн журмын дагуу олгосноос хойш Даатгуулагч гарсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн тохиолдолд Даатгуулагч нь олгогдсон н төлбөрийг үл маригах журмаар даатгагчид шилжүүлнэ.
 - 4.11 Буруутай этгээдээс хохирлыг нэхэмжлэн авах даатгагчийн эрхийг даатгуулагчийн зүгээс ямар нэгэн хэлбэрээр хязгаарласан эсвэл багасгасан тохиолдолд даатгагч даатгуулагчид ол нөхөн төлбөрийг гэр хэмжээгээр буцаан нэхэмжлэнэ.
 - 4.12 Даатгуулагч нь даатгалын зүйлийг хэд хэдэн компанид зэрэг даатгуулсан болон энэхүү даатгалын гэрээгээр олгогдох нөхөн төлбөр нь өөр даатгалын гэрээгээр мөн нөхөн төлөгдө байвал Даатгагч нь учирсан хохирлыг бүрэн хэмжээгээр хариуцахгүй бөгөөд бусад даатгалын компанитай тохиролцож хохирлын хэмжээнээс ихгүй байхаар тооцож нөхөн төлбөрийг олгон.
- Тав. Даатгалд хамрагдахгүй нөхцөл**
- 5.1 “Даатгалын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасан дараах үндэслэлээр нөхөн төлбөр олгохоос татгалзана. Үүнд:
 - 5.1.1 Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;

Утас: 7575 6000

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, G center, 3, 4 давхц

Зураг 32. М/Г даатгалтай байгуулсан гэрээ

“НУУР” НЭРТЭЙ ТООСГОНЫ ШАВРЫН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ, ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

7/22/22, 10:37 AM

<https://192.168.20.86:8111/MeduulgiinMayagt.aspx?ContractId=786358>

MVG ДААТГАЛ

ДААТГАЛЫН БАТАЛГАА: Иргэдийн гэнэтийн ослын даатгал
ГЭРЭЭНИЙ ДУГААР: **221041023320072**

2022 оны 07 сарын 22 өдөр

Даатгуулагчийн үндэн мэдээлэл:
Даатгуулагчийн овог: ИГОР
Даатгуулагчийн нэр: ЭНХ
Утас: 99823143

Регистрийн дугаар: ЧГ62091070
Хаяг: 28-Р ХОРОО 4-19 ТООТ


Даатгалын гэрээний хугацаа:
Эхлэх хугацаа: 2022 оны 07 сарын 22 өдрөөс - Дуусах хугацаа: 2023 оны 07 сарын 21 өдрийг дуустал
Даатгалын торлийн нэмэлт бүртгэлүүд:


Даатгалын гэрээний үндгээ, хураамж:

ТӨРӨЛ	ҮНЭЛГЭЭ	ҮНДСЭН ЭРСДЭЛ		НЭМЭЛТ ЭРСДЭЛИЙН ХУРААМЖ	НИЙТ ХУРААМЖИЙН ДҮН
		ХУВЬ	ХУРААМЖ		
Иргэдийн гэнэтийн ослын даатгал	2,000,000.00	0.7	14,000.00	0.00	14,000.00

Даатгуулагчийг төлөөлж:
Гарын үсэг: 
(Тамга, тэмдэг)

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Зуучлагчийг төлөөлж:
Гарын үсэг: 
(Тамга, тэмдэг)

Даатгуулагчийг төлөөлж:
Гарын үсэг: 
(Тамга, тэмдэг)

Даатгалын компанитай холбогдох:

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, G center, 3.4 давхар
Утас: 75756000 Факс: 330132 Нөхөн төлбөрийн алба: 70003000

• Тайлбар: Даатгалын баталгаа болон даатгалын гэрээг тус бүр 3 хувь үйлдэж, 1 хувь нь теллерт, 1 хувь нь харилцагчид, 1 хувь нь даатгалын байгууллагад очно. Даатгалын баталгаа нь даатгалын гэрээний салшгүй нэг хэсэг болно.



<https://192.168.20.86:8111/MeduulgiinMayagt.aspx?ContractId=786358>

1/1

Зураг 33. Даатгуулагчийн мэдээлэл

“СҮМБЭР ХУНТАН” ХХК-ИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 13 ны өдөр

№ А/03

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан таслах орон тооны бус
комисс томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолын хавсралтаар
баталсан Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм, Хөдөлмөрийн тухай
хуулийн 125 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг Компаний хэмжээнд ажилтан ажил олгогчдын хооронд гарсан
хөдөлмөрийн харилцааны холбогдолтой аливаа маргааныг дүрмийн дагуу судлан,
хэлэлцүүлж шийдвэрлэж байх зорилгоор хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан
таслах орон тооны бус комиссыг дараах хүмүүсийн бүрэлдэхүүнтэй байгуулан
ажиллуулсугай Үүнд:

Комиссын дарга	/ Гүйцэтгэх захирал /
Гишүүдэд	/ ХАБ-ын ажилтан /
	/ Дотоод хяналтын ажилтан /

Хоёр. Байгууллагын хэмжээнд хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм
журмыг боловсруулан батлуулж мөрдөх, хөдөлмөрийн харилцааны холбогдолтой
аливаа маргааныг дүрмийн дагуу судлан шийдвэрлэж ажиллахыг комиссын дарга,
гишүүдэд даалгасугай



ЗАХИРАЛ *Б.СОДНОМ* Б.СОДНОМ

Зураг 34. Ажилд авах тухай захирлын тушаал

“Сүмбэр хунтан” ХХК

Хөдөлмөрийн гэрээ

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

2022 оны 05-р сарын 12-ны өдөр

№ 06

Улаанбаатар хот

Энэхүү Хөдөлмөрийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г:

Нэг талаас, “Сүмбэр хунтан” ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал ажилтай Б.Содном (цаашид “Ажил олгогч” гэх),

Нөгөө талаас, тус компанид *Могоев* албан тушаалтай *Дамсралдор* овогтой *Хасгал Ойзуу* ИРД: *U2600425051* (цаашид “Ажилтан” гэх), нар (хамтад нь “Талууд” гэх) Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 47- зүйлийн 1,2 дах заалт, Компанид мөрдөж буй Хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг үндэслэн дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Талууд Хөдөлмөрийн гэрээний гол нөхцөлүүдийг дараах байдлаар харилцан тохиролцов. Үүнд:

Ажлын байрны нэр:	<i>Могоев</i>
Гүйцэтгэх ажил, үүрэг:	Ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу
Цалин хөлсний хэмжээ:	
Сул зогсолтын үеийн олговор:	Хөдөлмөрийн тухай хуулийн 116 дугаар зүйлд заасны дагуу
Хөдөлмөрийн нөхцөл:	
Ажил үүрэг гүйцэтгэх баршил:	Улаанбаатар хот (шаардлагатай тохиолдолд албан томилолтоор эсхүл ажлын шугамаар хөдөө орон нутагт)

1.2. Энэхүү Гэрээгээр Ажилтан нь Ажил олгогчоос олгосон албан тушаалын хүрээнд түүний заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу олгосон техник хэрэгсэл, хөдөлмөрийн багаж хэрэгслээр энэхүү гэрээ болон хөдөлмөрийн дотоод журам, энэхүү гэрээний хавсралт болох ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэх, ажил олгогч нь Ажилтныг ажлын байраар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин, хөлс олгохтой холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулна.

1.3. Ажлын байранд тавигдах ур чадвар, чадамжийн шаардлага:
/Нягт нямбай, хурдан шуурхай ажиллах, дүн шинжилгээ хийх, судалгаа шинжилгээ хийх чадвартай, гадаад хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй, хувийн зохион байгуулалт сайтай, есөж дэвших, өөрийгөө хөгжүүлэх чин хүсэл эрмэлзлэлтэй, компьютер дээр бичих шивэх чадвартай, компьютерийн хэрэглээний программ (MS word, excel, powerpoint, outlook) ашиглах, интернэтийн орчинд ажиллах чадвартай/

1.4. Ажил олгогч Ажилтантай энэхүү Гэрээний салшгүй хэсэг болох нууцлалын гэрээ, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг байгуулж, ажлын байрны тодорхойлолтыг танилцуулж, гарын үсгийг нь зуруулна.

1.5. Энэхүү Гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба талуудын хооронд өмнө нь байгуулсан аливаа хөдөлмөрийн гэрээ, эсхүл хөлсөөр ажиллах гэрээ дуусгавар болж, энэ Гэрээ нь талуудын хөдөлмөрийн эрх зүйн харилцааг зохицуулах үндсэн гэрээ болж үйлчилнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Энэхүү гэрээг Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д заасны дагуу хугацаагүй байгуулав.

Гурав. Ажил олгогчийн эрх, үүрэг

3.1. Ажил олгогч нь дараах эрхтэй:

3.1.1. Ажил олгогч нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан баталж, мөрдүүлэх ба хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх, ажлын хариуцлагыг

- дээшлүүлэх, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах талаар холбогдох арга хэмжээ авч түүний биелэлтэнд байнга хяналт тавих эрхтэй;
- 3.1.2. Гэрээнд заасны дагуу үүрэгт ажил болон хариуцлагаа ухамсарлан ажиллахыг ажилтнаас шаардах;
- 3.1.3. Шаардлагатай тохиолдолд Ажилтныг хуулиар тогтоосон хэмжээнд илүү цагаар ажиллуулах;
- 3.1.4. Ажил олгогч нь ажилтны амьдрал, ахуйд гачигдал, зовлон тохиолдсон болон шаардлагатай бусад нөхцөлд тогтоосон журмын дагуу тэтгэмж олгож, дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- 3.1.5. Ажилтан нь хөдөлмөрийн гэрээний хугацаанд эсхүл ажлаас чөлөөлөгдсөний дараа энэхүү гэрээ, компанитай байгуулсан бусад гэрээ, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бол гэрээ болон хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг таслан зогсоолгож, компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 3.1.6. Хөдөлмөрийн дотоод журам, энэхүү гэрээ, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн үүрэг болон компанийн удирдлага болон шууд хариуцан ажиллаж буй ажилтны тавьсан ажлын шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь, чанартай биелүүлэхийг ажилтнаас шаардах эрхтэй.
- 3.1.7. Ажилтнуудын ажлын цагийн ирц, ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн болон ёс зүйн сахилга хариуцлагын байдалд байнгын хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч, зөрчил, дутагдал гарсан тухай бүрд Хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу холбогдох арга хэмжээ авах;
- 3.1.8. Ажилтны ажил үүргийн зохион байгуулалтыг хийхдээ тухайн албан тушаалтны ажлын байранд мөрдөж ажиллах ажлын байрны тодорхойлолтыг үндэслэх, байнгын ажлын байраар хангах буюу томилолтоор ажиллуулах;
- 3.1.9. Ажил олгогчийн санаачлагаар зохион байгуулж буй олон нийтийг хамарсан бүхий л арга хэмжээнд ажилтнуудыг татан оролцуулах;
- 3.1.10. Ажилтныг ажлын байрны ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг шаардах, ажлын алдаа зөрчил гаргасан бол ил тод нээлттэй мэдээлэх, ганцаарчлан зөвлөгөө өгөх, хамт олны хурлаар хэлэлцүүлэх, бичгээр сануулах;
- 3.1.11. Ажил үүргээ, зохих ёсоор биелүүлж, амжилт гаргавал төр, засгийн шагналд тодорхойлох, ажлын байрны амжилтын хуудас гардуулах, сар, улирал бүрээр ажлын дүгнэж компанийн хэмжээнд мэдээлэх, сайшаах, цалингийн шатлал нэмэх;
- 3.1.12. Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журам, энэхүү гэрээний дагуу хөдөлмөрийн гэрээг цуцлах буюу сунгах;
- 3.2. Ажил олгогч нь дараах үүрэгтэй:**
- 3.2.1. Ажил олгогч нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулан баталж, компанийн нэгжүүдэд мөрдүүлэх ба хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах талаар холбогдох арга хэмжээ авч түүний биелэлтэд байнга хяналт тавьж ажиллах;
- 3.2.2. Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг журмыг баримтлан ажилтныг ажлын аятай нөхцөлөөр хангах, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай өрөө тасалгаа, техник хэрэгсэл, бичиг хэргийн материал, ажил, үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн зориулалтын дүрэмт хувцас болон тээврийн хэрэгслээр ханган аюулгүй найдвартай тээвэрлэлт, үйлчилгээ үзүүлэх нөхцөлөөр хангах арга хэмжээ авах;
- 3.2.3. Ажил олгогч нь хөдөлмөрийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, ажилтныг мэргэжил, мэргэшлийнх нь дагуу ажиллуулах;
- 3.2.4. Ажилтныг ажил үүрэгтэй холбоотой бөгөөд шаардлагатай бодлого, журам, заавар дүрэмтэй танилцах боломжоор хангах;
- 3.2.5. Ажил олгогч нь Ажилтныг хууль тогтоомжийн дагуу нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулж, хуульд заасан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэлийг холбогдох журмын дагуу төлөх;
- 3.2.6. Ажил олгогч нь тухайн Ажилтны ажил, албан тушаалыг хуульд заасан тохиолдолд хэвээр хадгалах;
- 3.2.7. Ажилтны боловсрол мэдлэгийг дээшлүүлэх мэргэжлийн сургалт семинар уулзалтыг зохион байгуулж хамруулах;
- 3.2.8. Аюулгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын орчноор хангах;
- 3.2.9. Ажилтны ажил үүргээ гүйцэтгэх дур сонирхлыг төрүүлж, компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэхийн төлөөх идэвхжүүлэлтийн арга хэмжээг авч ажиллах;
- 3.2.10. Гэрээнд заасны дагуу ажилтны цалин хөлсийг хугацаанд нь олгох үүрэгтэй.
- 3.2.11. Ажилтны цалин хөлс, олговор, тэтгэмжийг гэрээнд заасан цаг хугацаанд олгох;
- 3.2.12. Ажилтны ажил, албан тушаалыг хуульд заасан тохиолдолд хэвээр хадгалах.

Дөрөв. Ажилтны эрх, үүрэг

4.1. Ажилтан нь дараах эрхтэй:

- 4.1.1. Ажилтан нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авах, Хөдөлмөрийн дотоод журамд заасан бусад эрх, хөнгөлөлт эдлэх;
- 4.1.2. Ажилтан нь хариуцсан ажил, үүрэгтэйгээ шууд холбоотой асуудлаар үзэл бодол, санал хүсэлтээ байгууллагын удирдлагуудад чөлөөтэй илэрхийлэх;
- 4.1.3. Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхийн тулд ажил олгогчоос хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах эрхтэй;
- 4.1.4. Ажил үүргээ хугацаандаа гүйцэтгэсэн тохиолдолд цалин хөлсөө хугацаандаа авах;
- 4.1.5. Компанийн бизнес, үйл ажиллагаатай холбоотой оновчтой санал, хүсэлт, шинэ санаачлалыг хэзээд ч илэрхийлж болох ба гэрээний биелэлттэй холбоотой шаардлага тавих;
- 4.1.6. Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журамд заасан нөхцөл, шаардлага хангасан тохиолдолд амралт, чөлөө авах.

4.2. Ажилтан нь дараах үүрэгтэй:

- 4.2.1. Ажилтан нь компанийн бодлого, стратеги, бизнес төлөвлөгөө, жил, улирал, сар, долоо хоногийн төлөвлөгөөний дагуу хариуцсан ажлаа чанарын өндөр түвшинд гүйцэтгэх;
- 4.2.2. Ажилтан нь Ажил олгогчоос хариуцуулсан ажил, албан тушаалын үүрэгт ажлыг үнэнч шударга, хариуцлагатай гүйцэтгэж, эрхэлсэн ажилдаа үр дүнтэй, идэвх санаачлагатай ажиллаж, байгууллагын эд хөрөнгийг зохистой, хэмнэлттэй зарцуулан, гүйцэтгэх ажил, үүрэгтэй холбогдох хууль, эрх зүйн акт, дүрэм журам, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм журам, нууцлалын гэрээ, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг мөрдөж, энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;
- 4.2.3. Ажилтан нь өөрийн мэдлэг боловсрол, мэргэжлийн чадвараа байнга дээшлүүлэх, ажлын арга барилаа боловсронгуй болгох талаар өөртөө байнга шаардлага тавьж, идэвх, санаачлагатай ажиллах;
- 4.2.4. Ажилтан нь өөрт олгогдсон албан тушаалын дагуу олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэн хортойгоор ашиглахгүй байх, эзэмшилдээ байгаа эд зүйл, өмч, хөрөнгийг ашиглан шамшигдуулах буюу дур мэдэн ажлын байрнаас авч гарахгүй байх, байгууллагын нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийн нэр төрөл, ангилал, үнэ тариф, технологи, ажиллах зарчим, аливаа лиценз, дамжуулан авсан лиценз, бусад франчайзингийн эрх, барааны тэмдэг, оюуны өмч, үйлчилгээний гарын авлага ба арга стандарт, ажиллагаа, бизнесийн санаа, дотоод үйл ажиллагааг бусдад задруулахгүй байх, компанид ажиллаж байх үедээ эсхүл компаниас гарсны дараа хувьдаа ашиглахгүй байх, бусдад ашиглуулахгүй байх, компанийн удирдлага, харилцагч, үйлчлүүлэгч, түншүүдийн хувь хүний болон бизнесийн нууцыг чандлан хадгалах, бусдад задруулахгүй байх;
- 4.2.5. Ажлын байрны тодорхойлолтын дагуу эрхэлсэн ажилдаа идэвхи, санаачлагатай, бүтээлч сэтгэлгээтэй хандаж, өндөр гүйцэтгэл, үр дүнтэй ажиллах;
- 4.2.6. Компанийн нууц мэдээ, мэдээллийг агуулсан баримт бичгийг ажлын зорилгоор ашигласныхаа дараа шаардлагатай баримт бичгүүдийн хуулбарыг заавал устгах үүрэгтэй.
- 4.2.7. Ажилтан нь харилцааны өндөр соёл, мэргэжлийн үйл ажиллагааны болон хувийн ёс зүйн хэм хэмжээг байнга сахиж ажиллах ба ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах;
- 4.2.8. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ бүрэн биелүүлж, ажил олгогч буюу компанийн удирдлага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах;
- 4.2.9. Ажилтан нь цалин хөлснөөс бусад мөнгөн орлогод ногдох эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, татвар хураамжийг хуулийн дагуу өөрөө хариуцах;
- 4.2.10. Ажилтан нь эрхэлсэн ажилтай нь холбогдуулан өөрт нь бүрэн хариуцуулахаар олгосон техник хэрэгсэл, ажлын багаж, хамгаалах хэрэгсэл, тусгай хувцас, хэрэгсэл, эд хогшил зэрэг эд хөрөнгийг эвдсэн, гэмтээсэн, үрэгдүүлсэн, устгасан, ашиглан шамшигдуулсан тохиолдолд тухайн хохирлыг бүрэн төлж барагдуулах;
- 4.2.11. Ажилтан нь өөрийн гүйцэтгэж буй ажил үүрэгтэй холбоотой баримт бичиг, материалуудыг эмх цэгцтэй байлгаж, баримт бичгүүдийн бүртгэлийг цаг тухайд нь хөтөлж, баримтжуулан холбогдох материалд хавсарган архивлуулах;
- 4.2.12. Ажлын байрандаа архи тамхигүй орчинг бүрдүүлж, хамт олны дунд эвсэг нөхөрсөг харьцааг эрхэмлэх;
- 4.2.13. Ажил олгогчийн тогтоосон дүрэм журмын дагуу ажлын байрны тодорхойлолтод заасан үүрэгт ажлаа цаг тухайд нь хариуцлагатай гүйцэтгэх;
- 4.2.14. Хуулиар хориглосон, удирдлагын зөвшөөрөлгүй явуулсан үйл ажиллагаа, үйлдлийнхээ хариуцлага, учирсан хохирлыг ажилтан өөрөө хариуцан төлж барагдуулах;
- 4.2.15. Компанийн үйл ажиллагаа, үйлчилгээг чанартай үзүүлэн харилцагч үйлчлүүлэгч бүртэй эелдэг боловсон харьцаж компанийн имиджийг сэвтүүлэхгүйгээр соёлтой ажиллах үүрэгтэй.

Зургаа. Цалин хөлс

- 6.1. Ажилтны цалингийн хэмжээг тухайн ажил албан тушаалын онцлог, чиг үүрэг, хариуцлага, ачаалал зэргийг харгалзан компанийн удирдлагын шийдвэрээр шатлалтайгаар тогтооно.
- 6.2. Ажилтны үндсэн цалинг 2 хувааж олгох ба эхний цалинг тухайн сарын 20-нд, сүүл цалинг дараа сарын 05-ны өдөр тус тус олгоно. Хэрэв цалин олгох өдөр нь баярын болон амралтын өдөр таарвал өмнөх ажлын өдөрт олгоно.
- 6.3. Ажилтан өөрийн буруугаас ажил олгогчоос даалгасан, хариуцуулсан ажил, үүргийг биелүүлээгүй, бага цаг ажилласан бол гүйцэтгэсэн ажилд нь тохирсон цалин хөлс олгоно.
- 6.4. Ажил олгогч нь ажилтны цалингаас сар бүр эрүүл мэнд болон нийгмийн даатгалын шимтгэл, Хувь хүний орлогын албан татварыг хуулинд заасан хэмжээгээр суутган авч, төрийн холбогдох байгууллагуудад төлнө.
- 6.5. Ажилтан идэвхи, санаачлагатай, үр дүнтэй ажилласан, компанийн орлого ашгийг мэдэгдэхүйцээр нэмэгдүүлж чадсан нөхцөлд компанийн дотоод дүрэм, журамд заасны дагуу ажил олгогч өөрийн ашиг, орлогоос хамааран нэмэгдэл хөлс /урамшуулал/ олгоно.

Долоо. Эд материалын ашиглалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа

- 7.1. Ажилтан нь үүрэгт ажлаа гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгсэл, төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлган, ажил олгогчоос өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь хийж гүйцэтгэнэ.
- 7.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь ажилтанд түүний ажил албан тушаалын онцлогтой холбогдуулан ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай буюу хэргэцээтэй эд хөрөнгийг акт үйлдэн, хүлээлгэн өгнө.
- 7.3. Ажилтан нь өөрт хариуцуулан олгосон компьютер, бусад тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг бүрэн хариуцна.
- 7.4. Ажилтан нь тусгай маягтын дагуу ажил олгогчид хүсэлт гарган зөвшөөрөл авсны үндсэн дээр тээврийн хэрэгсэл, өөрт нь хариуцуулаагүй багаж тоног төхөөрөмж, бусад эд зүйлсийг ашиглах ба ашиглах хугацаандаа тухайн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг бүрэн хариуцна.
- 7.5. Ашиглаж буй техник хэрэгсэл, багаж, эд хөрөнгө, бусад тоног төхөөрөмжийн хэвийн бус үйл ажиллагааны талаар ажил олгогчид нэн даруй мэдэгдэн шаардлагатай арга хэмжээ авна.
- 7.6. Ажлаас гарах тохиолдолд ажилласан хугацаандаа ажил олгогчоос хүлээн авсан эд зүйлийг буцаан өгч, төлбөр тооцоог хийх ба эд материалыг эс хүлээлгэн өгсөнтэй холбоотойгоор үүссэн хохирлыг бүрэн барагдуулна.
- 7.7. Ажлаас гарсны дараа компанийн лого бэлгэ тэмдгийг ашиглахыг хориглох бөгөөд, байгууллагын нууцыг задруулахгүй байх үүрэгтэй төдийгүй байгууллагын нууцыг бусдад задруулсан тохиолдолд ажил олгогч нь хуулийн дагуу гомдол гаргаж хохирлоо барагдуулна.
- 7.8. Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан багаж хэрэгсэл, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг Ажилтанд хариуцуулан өгч, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулна.
- 7.9. Ажилтан нь өөрт нь хариуцуулан олгосон ажлын хувцас, багаж, техник хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг Ажил олгогчоос тогтоосон хугацаа буюу үйлдвэрийн баталгаат хугацаанд эдэлж хэрэглэх үүрэгтэй.
- 7.10. Ажилтан нь өөрийн хариуцан авсан ажлын хувцас, тээврийн хэрэгсэл, хэрэглэл, хамгаалах хэрэгсэл, эд хөрөнгийг хугацаанаас нь өмнө өөрийн буруугаас элэгдүүлсэн, өөрчилсөн, сольсон, өнгө үзэмжийг нь алдагдуулсан, гэмтээсэн, багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг гэмтээсэн, ашиглалтын горимыг нь алдагдуулсан, алдаж гээгдүүлсэн тохиолдолд компанид учирсан хохирол, холбогдох төлбөрийг ажилтны гэм бурууг харгалзан түүний үндсэн цалингаас Ажил олгогч нь суутган авна.
- 7.11. Ажилтан нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг ажиллагааг өөрөө ханган ажиллах үүрэгтэй бөгөөд ийнхүү хангаж ажиллаагүйгээс эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон, бусдад хохирол учруулсны хариуцлагыг ажилтан өөрөө бүрэн хариуцах үүрэгтэй.

Найм. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болох үндэслэл

- 8.1. Ажил олгогч нь Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуульд заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох /цаашид “гэрээг цуцлах” гэх/ буюу цуцална.
- 8.2. Энэхүү Гэрээг ажилтны санаачилгаар цуцлахаар бол Ажилтан нь Ажил олгогчид урьдчилан 30 хоногийн өмнө ажлаас гарах өргөдөл эсхүл Гэрээг цуцлах тухай бичгэн мэдэгдлийг заавал өгнө. Ажлаас гарах өргөдөл өгсөн ажилтны ажлын байранд дараагийн ажилтныг хайх, ажил, албан тушаалыг хүлээлцүүлэхэд хугацаа хэрэгтэй байх тохиолдолд ажил олгогч нь өргөдлөө өгсөн ажилтныг 30 хоног ажиллуулах эрхтэй бөгөөд ажилтан нь 30 хоног ажиллах үүрэгтэй болно.

- Хэрэв ажил олгогч ажилтантай тохиролцсон нөхцөлд Гэрээг энэхүү 30 хоногоос өмнө цуцалж болно.
- 8.3. Хэрэв Ажилтан гэрээний 8.2-т заасан өргөдөл эсхүл мэдэгдлийг ажил олгогчид бичгээр өгөлгүй ажил хаяж явсан тохиолдолд Ажил олгогч ажилтны хаягаар Гэрээ цуцлах тухай мэдэгдлийг хүргүүлэх бөгөөд шуудангийн хүргэлтийн компанид хүлээлгэн өгснөөс хойш ажлын нэг хоногийн дараа мэдэгдлийг хүргүүлсэн хэмээн тооцож, Гэрээг дангаараа дуусгавар болгоно.
- 8.4. Ажилтан урьдчилан мэдэгдэлгүйгээр ажлаа хаяж явсанаас үүдэн тухайн ажлын байран дээр дараагийн ажилтныг авахад хугацаа шаардагдах, ажиллах ажилтангүйн улмаас компани үйл ажиллагаагаа бүрэн эсхүл хэсэгчлэн явуулж чадаагүйгээс болж компани ашиг орлогоо алдсан, компанид хохирол учирсан тохиолдолд уг хохирлыг ажилтны үлдэгдэл цалингаас суутгах бөгөөд суутгахад хүрэлцэхгүй байх тохиолдолд үлдсэн хохирлыг ажилтнаар нөхөн төлүүлнэ.
- 8.5. Ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг шууд зогсоход хүргэх ажилтны зүгээс гаргасан ноцтой зөрчил гэдэгт дараах зөрчлүүдийг хамааруулна. Үүнд:
- 8.5.1. Компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, хэвийн үйл ажиллагааны горим, нэр хүндэд нөлөөлж, харшлах зөрчил дутагдал гаргасан;
- 8.5.2. Нууц хадгалах, нууцтай харьцах журам болон Нууцлалын гэрээний заалтыг зөрчиж, Компани, түүний удирдлагын болон үйлчлүүлэгч, харилцагч, түншийн аливаа нууцыг задруулсан;
- 8.5.3. Удирдлагын зөвшөөрөлгүйгээр компанийн бодлого, үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгөх, сонин сэтгүүл, хэвлэл, сошиал медиад нийтлэл бичих, мэдээлэл тавих;
- 8.5.4. Ажилтан хууль бус үйлдэл (гэмт хэрэг, захиргааны болон сахилгын зөрчил г.м) хийсэн болох нь нотлогдсон, хууль бус үйлдлийн улмаас компанийн нэр хүнд болон эд хөрөнгөд хохирол учирсан;
- 8.5.5. Ажилд орохдоо эрүүл мэндийн байдал, хувийн мэдээлэл, мэргэжил, диплом баримт бичиг болон бусад чухал хүчин зүйлийг хуурамчаар танилцуулсан, бүрдүүлсэн;
- 8.5.6. Албан тушаалын эрх мэдэл, эрхэлсэн ажлынхаа аливаа давуу тал, компаниас албан ажилд нь зориулж олгосон хангамж, эд хөрөнгө, хүлээлгэсэн итгэлийг хувийн ашиг сонирхолд урвуулан буюу албаны бус зүйлд ашигласан /ажил үүргээ гүйцэтгэсний төлөө бусдаас шан харамж авсан, хувьдаа үйлчилгээ авсан, компанийн өмч хөрөнгийг хувьдаа завшсан, хэрэглэсэн, бусдад зориуд завшуулсан, компанийн зардлаар хувийн хэрэгцээг хангасан, хувийн бизнесийг дэмжсэн гэх мэт/;
- 8.5.7. Нэгжийн удирдлага, удирдах албан тушаалтан эсхүл Гүйцэтгэх Захирлын тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг 1 ба түүнээс дээш удаа хугацаанд нь биелүүлээгүй, компанийн удирдлага, ажилтантай 2 ба түүнээс дээш удаа хэрэлдэж, маргалдсан;
- 8.5.8. Ажил олгогчид урьдчилан мэдэгдэлгүйгээр нэг сарын дотор 30 компаниас дээш хугацаагаар 5 буюу түүнээс дээш удаа ажлаас хоцорсон, 8-аас дээш цаг ажил тасалсан, эсхүл ажлын байраа зөвшөөрөлгүй орхисон;
- 8.5.9. Удирдах албан тушаалтанд урьдчилан мэдэгдэж албан ёсоор чөлөө авалгүй нэг ба түүнээс дээш өдөр ажил тасалсан, орхиж явсан эсхүл ажил тасалсан цагууд нийлбэрээр 8 цаг ба түүнээс дээш гарсан, чөлөөний хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн;
- 8.5.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн горимыг ноцтой эсхүл удаа дараа зөрчсөн;
- 8.5.11. Компанийн эд хөрөнгө, компьютер, техник тоног төхөөрөмж болон бусад ажилтнуудын эд зүйлсийг хулгайлсан, хулгайлахаар завдсан, байгууллагын эд хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй авч явсан, хувьдаа ашигласан, гадуур авч явсан, бусдад дамжуулсан, ашиглуулсан болон санаатайгаар дутаасан;
- 8.5.12. Албан тушаалын эрх мэдлээ урвуулан, хэтрүүлэн ашигласан, албан үүргээ биелүүлсний төлөө харилцагч байгууллага, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж шаардсан, авлига авсан;
- 8.5.13. Ажлын цагаар /томиллолтоор ажиллах/ болон ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ ажлын байранд нэвтэрсэн;
- 8.5.14. Ажлын байранд компанийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахуйц нөхцөл байдлыг үүсгэн танхайрсан, хамт олны эвсэг байдалд сөргөөр нөлөөлөхүйц харилцааны зүй бус үйлдэл гаргасан, хамт олныг хагалан бутаргах үйлдэл хийх, хамтран ажиллагчийнхаа нэр төрийг гутаах, доромжлох, ажилд нь саад болох, ажлын бүтээмжийг санаатайгаар бууруулах, бусдыг ийм үйлдэлд уриалах, компанийн удирдлага, аливаа ажилтан, харилцагч, үйлчлүүлэгч, түнштэй зодолдох, хэрэлдэх, маргалдах, танхайрах зэргээр зүй бус ёс зүйгүй авир гаргасан, бусад хууль бус үйлдэл /Үндэслэлгүй хов жив, цуурхал тараах, бусдын нэр төрд халдах, доромжлох, гүтгэх, дарамт шахалт үзүүлэх зэргээр хүний нэр төр, эрх чөлөөнд халдсан, компанийн эсрэг сурталчилгаа хийж бусдыг өдөөн тухирах, хамт олныг хагалган бутаргах үйл ажиллагаа явуулах/ гаргасан;

“Сүмбэр хунтан” ХХК

Хөдөлмөрийн гэрээ

- 9.9. Ажилтан Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын зөрчил гаргасны улмаас болон ажлын бус цагаар бусад зорилго, шалтгааны улмаас Компанид эд хөрөнгийн хохирол учруулсан бол ажилтанд сахилгын шийтгэл болон эд хөрөнгийн хариуцлагыг давхар хүлээлгэнэ.
- 9.10. Компани нь өөрт учирсан хохирлын хэмжээг дараах байдлаар тодорхойлно:
- 9.10.1. Компанид учирсан хохирлын хэмжээг эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийн компанийн нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцлийн өртгөөс зохих нормоор бодсон элэгдэл, хорогдлыг хасаж, жинхэнэ гарсан алдагдлаар тус тус тооцно.
- 9.10.2. Эд хөрөнгө, үнэ бүхий зүйлийг ажилтан ашиглан шамшигдуулсан, санаатайгаар устгасан, гэмтээсэн үед хохирлын хэмжээг эд хөрөнгийн тухайн үеийн зах зээлийн үнийн ханш эсхүл гаалийн үнээр тодорхойлно.
- 9.10.3. Хэд хэдэн ажилтны буруугаас учирсан хохирлын хэмжээг тэдгээрийн гэм буруугийн хэмжээ, эд хөрөнгийн хариуцлагын төрлийг харгалзан ажилтан тус бүрээр тодорхойлно.
- 9.10.4. Компани шаардлагатай гэж үзвэл Ажилтны учруулсан эд хөрөнгийн хохирлыг тогтоох, ажилтнаар төлүүлэх, холбогдох асуудлыг шийдвэрлэхтэй зорилгоор Гүйцэтгэх Захирлын шийдвэрээр түр ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.
- 9.10.5. Ажилтны буруугаас харилцагч, үйлчлүүлэгчээ алдсан, үйлчилгээг үзүүлж чадаагүй бол харилцагч, үйлчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээнээс олох ёстой байсан орлогыг хохиролд тооцно.
- 9.11. Ажилтан нь гэрээнд заасан хөдөлмөрлөх үндсэн үүрэг болон гэрээнд заасан бусад үүргийг Компанийн ажлын байран дээр гүйцэтгэдэг тул Ажилтанд холбогдуулан гаргах аливаа нэхэмжлэл, гомдол, шаардлагыг Компанийн оршин байгаа газрын шүүхэд гаргана.
- 9.12. Компани шаардлагатай гэж үзвэл Ажилтны учруулсан эд хөрөнгийн хохирлыг тогтоох, ажилтнаар төлүүлэх, холбогдох асуудлыг шийдвэрлэхтэй зорилгоор Гүйцэтгэх захирлын шийдвэрээр түр ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

Арав. Бусад зүйл

- 10.1. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талууд тус бүрд нэг хувь хадгалагдана. Гэрээний хувь тус бүр хууль зүйн ижил хүчин чадалтай байна.
- 10.2. Энэхүү Гэрээнд тусгагдаагүй хөдөлмөрийн эрхлэлтийн харилцаатай холбогдсон бусад асуудлыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон Хөдөлмөрийн дотоод журмын дагуу зохицуулна.
- 10.3. Ажил олгогч, Ажилтны хооронд маргаантай асуудал гарвал талууд харилцан ойлголцож, нэгдсэн тохиролцоонд хүрэхийг эрмэлзэнэ. Хэрэв талууд маргаантай асуудлаар нэгдсэн тохиролцоонд эс хүрвэл эвлэрүүлэн зуучлагчид хандахгүйгээр хуулинд заасан харьяаллын дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 10.4. Энэ Гэрээнд талууд харилцан тохиролцооноор нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба энэ тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, Гэрээнд хавсаргаж байна. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь энэхүү Гэрээний нэгэн адил хүчин төгөлдөрт тооцогдоно.
- 10.5. Энэ Гэрээнд хэрэглэгдэж байсан хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт орсон, эсвэл гэрээний эх сурвалж болж байсан нөхцөл, болзол өөрчлөгдсөний улмаас гэрээг цаашид хэрэгжүүлэх боломжгүй болсны улмаас гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн хүчингүй болгох нөхцөлд талууд тохиролцож гэрээг хуульд нийцүүлэн шинэчлэн өөрчилнө.
- 10.6. Гэрээний хавсралт нь Гэрээний салшгүй хэсэг байна.
- 10.7. Гэрээнд дараах баримт бичгийг хавсаргана:
- 10.7.1. Ажлын байрны тодорхойлолт
- 10.7.2. Ажилтны иргэний үнэмлэхийн хуулбар
- 10.7.3. Ажилтны мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээний хуулбар
- 10.7.4. Ажилтны үнэн зөв, бүрэн гүйцэт бөглөсөн анкет.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЖИЛТАН:

“Сүмбэр хунтан” ХХК-ийн Гүйцэтгэх
Захирал *С.Сүхбаатар* Б. Содном

Овог, нэр: *Давс-Селен*


/гарын үсэг/

/гарын үсэг/

“НУУР” НЭРТЭЙ ТООСГОНЫ ШАВРЫН ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ, ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 36. Манай компанид ажиллаж буй Сонгинохайрхан дүүргийн иргэд




Зураг 37. Байгаль орчны аудитын тайланг “Өртөөлөн” ХХК-тай гэрээ байгуулан хийлгүүлсэн

2022.08.24			
400.00	ЗАРЛАГА	Charges for PORD Customer Payment :000133210677 (ХАНШ:1.0000)	
7,243,500.00	ЗАРЛАГА	СҮМБЭРХУНТАН ХХК МИДЛИНГ ТӨЛБӨР, ШИНЭ-УЯНГА, ХААН Т В БАНК (ХАНШ:1.0000)	
7,501,929.00	ЗАРЛАГА	СҮМБЭРХУНТАН ХХК 2149878 ЦАХИЛГААН ТӨЛБӨР (ХАНШ:1.0000)	
100.00	ЗАРЛАГА	ДОТООД ГҮЙЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ (ХАНШ:1.0000)	

Зураг 38. Цахилгааны төлбөр төлсөн баримт

2.10 Аймаг нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ

Сонгинохайрхан дүүргийн 8-р хороотой хамтран тус хорооны нутагт байрлах Гүнжийн нүдэн нуур цогцолборын эвдэрсэн хүүхдийн тоглоомын талбайг дахин шинэчлэлт хийхэд зориулж 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.



Зураг 39. Хүүхдийн тоглоом суурилуулсан байдал

ГҮЙЛГЭЭ АМЖИЛТТАЙ ХИЙГДЛЭЭ. №
[33696345]

Огноо	2022/10/27 19:14
Х.ГҮЙ ХАД/ИРГЭД/ MNT: 5003 481 865	4,000,000.00 MNT
Гүйлгээний утга	ХОС МОНГОЛ СҮМБЭР ХУНТАН ХХК
Боломжит үлдэгдэл	<input checked="" type="checkbox"/> *****
Хүлээн авагчийн дансны дугаар	5018 695 383 MNT
Хүлээн авагчийн нэр	Г*****Н ГАНБААТАР

Зураг 40. Төлбөр төлсөн баримт

2.11 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан холбогдох байгууллагуудад танилцуулахаар хүргүүлсэн болно.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗАРЦУУЛСАН МӨНГӨН ДҮН

№	Мэдээллийн төрөл	Нийт зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10794.0
2	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөөгүй
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	2500.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	Төлөвлөөгүй
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөөгүй
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	642.4
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	7135.0
8	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт	250.0
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	4571.0
10	Аймаг нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	2000.0
11	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	ҮАЗ
	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн нийт төсөв	27892.4

ДҮГНЭЛТ

Манай компани нь 2022 оны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд 3 сар үйл ажиллагаа явуулсан. Энэ хугацаанд байгаль орчны хамгаалах ажлын хүрээнд 27892.4 мян.төгрөгийг зарцуулсан байна. Мөн 2022 онд байгаль барьцаа хөрөнгө 1835.0 төгрөгийг Төрийн сангийн дансанд байршуулсан.